



МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 128 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.


2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Д.Цэцэгмаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТ-ЭРДЭНЭ



Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 22 дугаар сарын 17-ны өдрийн 53 дугаар тогтоолын хавсралт

27

### ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцах гишүүн
1.	Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн шууд захирагчтай, төсвийн шууд захирагч менежерүүдтэй, менежерүүд төрийн албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах	1 дүгээр сард	Үр дүнгийн гэрээг зохих журмын дагуу бүх шатанд байгуулж, баталгаажуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ж.Гантөмөр
2.	Яамны төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох саналыг нэгтгэн боловсруулж, шийдвэрлүүлэх	1-2 дугаар сард	Журамд заасан шаардлага хангасан албан хаагчид зэрэг дэв бүрэн олгогдсон байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ж.Гантөмөр
3.	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулах	2 дугаар сард	Хөтөлбөрийг судалгаанд үндэслэн бодитой, үндэслэлтэй, үр дүнд хүрэх тодорхой зорилт, арга хэмжээг тусган боловсруулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ж.Гантөмөр
4.	Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулах	2 дугаар сард	Албан хаагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөтөлбөрийг боловсруулж батлуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Хуулийн хэлтсийн дарга Н.Бат-Эрдэнэ
5.	Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтныг сонгон шалгаруулах, дүгнэлт гаргах, нөөц бүрдүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах	Жилдээ	Хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн зохион байгуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ж.Гантөмөр

6.	Ажлын байрны тодорхойлолтын дагуу албан хаагчдыг төрийн жинхэнэ албан тушаалд томилох, нөөцөөс нөхөх, ажлын байрны сул орон тоог нээлттэй, ил тод зарлах арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу хийж гүйцэтгэх	Жилдээ	Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн ил тод, нээлттэй байдлыг хангасан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ж.Гантөмөр
7.	Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон маргааныг хүлээн авч, маргаан хянан шийдвэрлэх комисс томилж шийдвэрлэх	Жилдээ	Маргаан хянан шийдвэрлэх комисс нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу асуудлыг судлан шийдвэрлэсэн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гомбосүрэн
8.	Төрийн албаны зөвлөлөөс гарсан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	ТАЗ-ийн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Цэцэгмаа
9.	Салбар зөвлөлийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагаатай танилцаж арга зүйн зөвлөгөө өгөх	9 дүгээр сард	Газрын үйл ажиллагааг бодитой үнэлж, цаашдын үйл ажиллагаанд дэмжлэг болохуйц санал, зөвлөмж өгсөн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гомбосүрэн
10.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, Ёс зүйн хороог арга зүйн удирдлагаар хангах	Жилдээ	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар бодитой арга хэмжээг хэрэгжүүлж, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг бүрэн өгч ажилласан байна.	Салбар зөвлөлийн гишүүд
11.	Ёс зүйн зөрчлийн болон өргөдөл, гомдол, маргааны мэдээг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	Хагас, бүтэн жилээр	Холбогдох мэдээг журамд заасны дагуу нэгтгэн гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Хуулийн хэлтсийн дарга Н.Бат-Эрдэнэ
12.	Яам, агентлагийн хэмжээнд төрийн албаны боловсон хүчний бүрэлдэхүүн хөдөлгөөнд тухай бүр баяжилт хийж холбогдох тайлан мэдээг тогтоосон хугацаанд Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	Хагас, бүтэн жилээр	Яамны төрийн албан хаагчдын мэдээллийг тухай бүр баяжуулж, шаардлагатай мэдээллийн санг бүрдүүлсэн байна. Тайлан мэдээг	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Цэцэгмаа

			тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	
13.	“Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулах албан хаагчийг тодруулж, санал бэлтгэж танилцуулах	6 дугаар сард	Газар, хэлтсүүдээс нэр дэвшүүлж, ТАЗСЗ-өөр хэлэлцүүлж, шалгарсан албан хаагчийн материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж, ТАЗ-д хүргүүлсэн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Цэцэгмаа
14.	Төрийн албаны зөвлөл болон яамны цахим хуудсаар тус салбар зөвлөлийн үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд ил тод, нээлттэй сурталчлах, холбогдох мэдээллийг түүнд байршуулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Яамны албан хаагчид болон бусад хэрэглэгчдэд мэдээллийг нээлттэй, шуурхай хүргэж ажилласан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ж.Гантөмөр
15.	Төсвийн ерөнхийлөн захирагч, менежер, төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, санал зөвлөмж гаргах	6, 12 дугаар сард	Гэрээний хэрэгжилтийн явц болон биелэлт, үр дүнг бодитой тодорхойлж, цаашдын үйл ажиллагаанд дэмжлэг болохуйц санал, зөвлөмж өгсөн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гомбосүрэн
16.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдааныг бэлтгэл ханган зохион байгуулах	Сар бүр	Холбогдох журмын дагуу хуралдааны бэлтгэлийг хангаж, зохион байгуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Цэцэгмаа

---- оОо ----